



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 148

Улаанбаатар хот

“Хадгаламж, зээлийн хоршооны дотоод хяналтын шалгах хуудасны үлгэрчилсэн загвар” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Хадгаламж, зээлийн хоршооны дотоод хяналтын шалгах хуудасны үлгэрчилсэн загвар”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэ тушаалын хавсралтаар батлагдсан үлгэрчилсэн загварын дагуу өөрийн хадгаламж, зээлийн хоршооны эрсдэлийг тогтмол үнэлж, эрсдэлээс урьдчилан сэргийлж, түүнийг бууруулах хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж ажиллахыг нийт хадгаламж, зээлийн хоршоодын удирдлагуудад зөвлөсүгэй.

3.“Хадгаламж, зээлийн хоршооны дотоод хяналтын шалгах хуудасны үлгэрчилсэн загвар”-ыг таниулан сурталчлах ажлыг зохион байгуулахыг Хадгаламж, зээлийн хоршооны газар (Ц.Алтантуул)-т үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

1518000374

Санхүүгийн зохицуулах хорооны даргын
2024 оны 03 дугаар сарын 29 ний өдрийн
148 дугаар тушаалын хавсралт



“.....” ХЗХ-НЫ
ДОТООД ХЯНАЛТЫН ШАЛГАХ ХУУДАС

Шалгасан он сар өдөр: 20...он.... сар ... өдөр

ДОТООД ХЯНАЛТЫН ШАЛГАХ ХУУДАСНЫ БҮРДЭЛ:

I. ШАЛГАХ ХУУДАСНЫ ЗААВАРЧИЛГАА

II. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД МӨРДӨХ ДҮРЭМ, ЖУРМУУД

Шалгах хуудас 1: Бодлогын баримт бичиг, дүрэм, журмууд

III. УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Шалгах хуудас 2: Тэргүүлэгчдийн зөвлөлийн үйл ажиллагаа

Шалгах хуудас 3: Зээлийн хорооны үйл ажиллагаа

Шалгах хуудас 4: Гүйцэтгэх албаны үйл ажиллагаа

IV. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Шалгах хуудас 5: Мөнгөн хөрөнгө

Шалгах хуудас 6: Зээлийн үйл ажиллагаа

Шалгах хуудас 7: Авлага, өр төлбөр

Шалгах хуудас 8: Үндсэн хөрөнгийн бүртгэл

Шалгах хуудас 9: Хадгаламжийн үйл ажиллагаа

Шалгах хуудас 10: Хоршооны өөрийн хөрөнгө, гишүүдийн хувь хөрөнгө

Шалгах хуудас 11: Орлого, зардлын данс

Шалгах хуудас 12: Тусгайлсан хяналт

Шалгах хуудас 13: Мэдээллийн аюулгүй байдал

V. ШАЛГАХ ХУУДАСНЫ НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ

I. ШАЛГАХ ХУУДАСНЫ ЗААВАРЧИЛГАА

“ХЗХ-ны дотоод хяналтын шалгах хуудас”-ыг хадгаламж, зээлийн хоршоо (цаашид “ХЗХ” гэх)-ны эрсдэлийг бууруулах, хяналтын зөвлөлийн чиг үүрэг, үйл ажиллагааг тогтмолжуулан мэргэшүүлэх зорилгоор Азийн хөгжлийн банкны төслийн зөвлөхийн дэвшүүлсэн загвар баримт бичигт тулгуурлан, хялбаршуулсан байдлаар боловсруулсан болно.

Шалгах хуудсыг хоршооны үйл ажиллагаанд хяналтын зөвлөлийн хийх дотоод хяналтыг цэгцтэй, иж бүрэн байдлаар явуулахад дөхөм болгох зорилгоор бүлэглэн ангилж, ангилал тус бүрт хамаарах асуулгыг тусгасан. Шалгах хуудасны дагуу хийж гүйцэтгэх ажиллагаа, асуулга нь зөвхөн загвар зөвлөмж тул тухайн ХЗХ өөрийн үйл ажиллагааны цар хүрээ, онцлогт тохируулан өөрчилж, боловсронгуй болгож хэрэглэх нь зүйтэй.

Энэхүү шалгах хуудасны дагуу шалгалтыг хийхдээ иж бүрэн болон хэсэгчлэн хийж болох бөгөөд энэ тохиолдолд шалгалт хийсэн хугацааг шалгах хуудас бүрт тэмдэглэх шаардлагатай. Нийт 150 асуултад “тийм”, “үгүй”, “хангалтгүй” гэж хариулах бөгөөд бүх хариултыг “тийм” гэсэн утга авах хүртэл зорьж ажиллана. Нэг асуултад нэгээс дээш агуулга орсон бөгөөд аль нэг агуулгад нь “үгүй” эсвэл “хангалтгүй” гэж хариулахаар байвал тухайн асуултад хамгийн бага утгаар хариулна. ХЗХ-нд тухайн асуулт хамааралгүй тохиолдолд хоосон орхиж, нэгдсэн үнэлгээнд хасаж тооцно.

Дүгнэлт зөвлөмж баганад тухайн шалгалттай холбоотой дүрэм, журам, тэдгээрийн заалт, харилцах данс, дэд дансдын хуулга, тайлан мэдээ, холбоотой гэрээ хэлцэл, нотлох баримт зэргийг дурдах ба тэдгээрийг хавсралтаар бүрдүүлнэ. Мөн энэ баганад тухайн шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдал болон түүнийг залруулах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой зөвлөмж хэлбэрээр дэлгэрэнгүй тусгаж өгнө.

Хяналтын зөвлөлийн гишүүд нь “Шалгах хуудас” 1-13-ын дагуу иж бүрэн шалгалтыг жилд нэгээс доошгүй, хэсэгчилсэн шалгалтыг шаардлагатай тухай бүр хийвэл зохино. Хийсэн шалгалтын тайлан болон цаашид анхаарч ажиллах зөвлөмжийг бичгээр гарган тэргүүлэгчдийн зөвлөл болон гүйцэтгэх албанд хүргүүлэх ба шалгалт хийсэн бүрэлдэхүүн гарын үсэг зурж баталгаажуулна.

Хяналтын зөвлөл шалгалтаар өгсөн зөвлөмжийн биелэлт, үр дүнг ээлжит хурлаараа дүгнэн хэлэлцэж, биелэлтийг хангуулж ажиллана.

II. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД МӨРДӨХ ДҮРЭМ, ЖУРМУУД

Шалгах хуудас 1: Бодлогын баримт бичиг, дүрэм, журмууд

№	Асуумж	Шалгуур үзүүлэлт (тийм/үгүй/хангалтгүй)	Дүгнэлт/ зөвлөмж
Дараах бодлогын баримт бичиг, дүрэм, журмуудыг баталсан ба үйл ажиллагаандаа мөрддөг			
1	Хадгаламж, зээлийн хоршооны дүрэм		
2	Хадгаламжийн үйл ажиллагааны бодлого		
3	Зээлийн үйл ажиллагааны бодлого		
4	Тэргүүлэгчдийн зөвлөлийн үйл ажиллагааны журам		
5	Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны журам		
6	Зээлийн хорооны ажиллах журам		
7	Хадгаламжийн үйл ажиллагааны журам		
8	Зээлийн үйл ажиллагааны журам		
9	Хадгаламж, зээлийн хоршооны бизнес төлөвлөгөө		
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг		
11	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх дотоод хяналтын хөтөлбөр, журам		

III. УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Шалгах хуудас 2: Тэргүүлэгчдийн зөвлөлийн үйл ажиллагаа

№	Асуумж	Шалгуур үзүүлэлт (тийм/үгүй/хангалтгүй)	Дүгнэлт/ зөвлөмж
1	Тэргүүлэгчдийн зөвлөлийн гишүүд хуулийн 34.3-д заасан шаардлагыг хангасан эсэх		
2	Хуулийн 34.6-д заасны дагуу тэргүүлэгчдийн зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа хүчинтэй байгаа эсэх		
3	Хуулийн 35.1.4-д заасны дагуу хадгаламж, зээлийн журмыг баталсан, хадгаламж, зээлийн хүүг тогтоосон эсэх		
4	Хуулийн 34.9-д заасны дагуу тэргүүлэгчдийн зөвлөл 30 хоногт нэгээс доошгүй удаа хуралдсан эсэх		
5	Тэргүүлэгчдийн зөвлөлийн өөрчлөлтийг “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавих нөхцөл, шаардлага”-д заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдсэн эсэх		
6	Тэргүүлэгчдийн зөвлөлийн үйл ажиллагааны журмыг мөрдөж ажилладаг эсэх		
7	Хадгаламж, зээлийн хоршооны бизнес төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, арга хэмжээ авч ажилладаг эсэх		

8	Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхэд хяналт тавьсан эсэх		
9	Гишүүдийн бүртгэлийг хөтөлж, гарсан өөрчлөлтийг хагас, бүтэн жилээр Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдсэн эсэх		
10	Санхүүгийн зохицуулах хороо, бүх гишүүдийн хурал болон хяналтын зөвлөлөөс өгсөн үүрэг даалгавар, шийдвэрийн биелэлтийг хангаж ажилласан эсэх		
11	Хуулийн 35.1.18-д заасны дагуу хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүн, гишүүнчлэл бүхий гүйцэтгэх захирал, ажилтанд зээл олгох зөвшөөрлийг олгож, зээлийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан эсэх		
12	Зээлийн хугацаа хэтрэлтийн тайланг хянаж, хэлэлцдэг эсэх		
13	Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд хяналт тавьдаг эсэх		
14	Хуулийн 31.1-д заасны дагуу бүх гишүүдийн ээлжит хурлыг 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор зарлан хуралдуулсан, хурлын ирц хуулийн дагуу шаардлага хангасан эсэх		
15	Хуулийн дагуу бүх гишүүдийн ээлжит хурлыг хуралдуулах зар болон хэлэлцэх асуудлын жагсаалтыг хурал хуралдахаас 30-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд хүргэсэн эсэх		
16	Жилийн санхүүгийн тайланг бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлсэн эсэх		
17	Тухайн жилийн орлогоос алдагдал нөхөх, сангуудад хуваарилах, гишүүдэд хүртээх хувь хөрөнгийн хэмжээний талаар санал боловсруулж, бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан эсэх		
18	Санхүү, төлбөрийн чадвар муудаж, өөрийн хөрөнгөгүй болоход бүх гишүүдийн хурлаар уг асуудлыг нэн даруй хэлэлцүүлсэн эсэх		
19	Тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны тайланг бүх гишүүдийн хурлаар хэлэлцсэн эсэх		
20	Хуулийн 33.3-т заасны дагуу бүх гишүүдийн хурлын тэмдэглэлд заавал тусгах мэдээллийг бүгдийг тусгасан эсэх		
21	Сонгуульт гишүүд, гүйцэтгэх албанд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу сургалтын хөтөлбөр гаргаж сургалт зохион байгуулдаг эсэх		
22	Хуулийн 39.2-т заасны дагуу гүйцэтгэх захирлын тайлагнасан ажлыг дүгнэдэг эсэх		
23	Хуулийн 39.7.4-т заасны дагуу гүйцэтгэх захирал нийт активын 10 хувиас доош хэмжээтэй нэг буюу хоорондоо шууд хамаарал бүхий хэд хэдэн хэлцэл хийх шийдвэр гаргах эрхээ хэтрүүлсэн эсэхийг шалгадаг эсэх		

Шалгах хуудас 3: Зээлийн хорооны үйл ажиллагаа

№	Асуумж	Шалгуур үзүүлэлт (тийм/үгүй/хангалтгүй)	Дүгнэлт/ зөвлөмж
1	Зээлийн хорооны гишүүд хуулийн 38.5-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэх		
2	Зээлийн хорооны үйл ажиллагааны журмыг мөрдөж ажилласан эсэх		
3	Тэргүүлэгчдийн зөвлөлөөс тогтоосон зээлийн хүүг мөрдөж ажилладаг эсэх		
4	Тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүд, гишүүнчлэл бүхий гүйцэтгэх захирал, ажилтанд зээл олгоход тэдгээрийн хашиж буй албан тушаалаас нь хамаарч аливаа давуу байдал, хөнгөлөлт эдлүүлээгүй эсэх		
5	Тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүд, гишүүнчлэл бүхий гүйцэтгэх захирал, ажилтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдэд зээл олгох асуудлыг шийдвэрлэх ажиллагаанд тухайн албан тушаалтанг оролцуулаагүй эсэх		
6	Хуулийн 38.6-д заасны дагуу зээлийн хороо нь хадгаламж, зээлийн хоршооны дүрэмд заасан хугацаанд тогтмол хуралдсан эсэх		
7	Зээлийн хорооны шийдвэрүүд Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль болон бусад дүрэм, журамд заасан бүрэн эрхийн асуудалд нийцэж байгаа эсэх		
8	Зээл олгоход шаардагдах баримт бичгийн бүрдэл бүрэн эсэх		
9	Зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьдаг эсэх		

Шалгах хуудас 4: Гүйцэтгэх албаны үйл ажиллагаа

№	Асуумж	Шалгуур үзүүлэлт (тийм/үгүй/хангалтгүй)	Дүгнэлт/ зөвлөмж
1	Гүйцэтгэх захирал хуулийн 39.6-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэх		
2	Гүйцэтгэх захирлын өөрчлөлтийг “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавих нөхцөл, шаардлага”-д заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдсэн эсэх		
3	Гүйцэтгэх албаны ажилчидтай гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьдаг эсэх		
4	Шаардлагатай өөрчлөлтүүдийг Санхүүгийн зохицуулах хороонд хугацаанд нь мэдэгдэж, бүртгэл хийлгэсэн эсэх		
5	Санхүүгийн тайланг Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороонд хугацаанд нь хүргүүлсэн эсэх		
6	Ажилчдын хувийн хэрэг үүсгэсэн, хувийн хэргийн бүрдэл бүрэн эсэх		
7	Гишүүдийн бүртгэлийг харилцагчийг таньж мэдэх шаардлагын дагуу бүрэн зөв хийсэн эсэх		
8	Гишүүдэд зориулсан сургалт зохион байгуулдаг эсэх		
9	Гишүүдэд сургалт зохион байгуулах зардлыг төсөвт тусгасан эсэх		

10	Ажилтнуудыг мэргэжлийн сургалтад хамруулдаг эсэх		
11	Гишүүдийн дунд нийгэм соёлын арга хэмжээ зохион байгуулдаг эсэх		
12	Гишүүд санал хүсэлтээ илэрхийлэх боломжийг бүрдүүлсэн эсэх		
13	Гишүүдээс ирсэн гомдол, саналыг хууль, журмын дагуу шийдвэрлэсэн эсэх		
14	Гишүүдэд мэдээллийг ил тод, нээлттэй хүргэдэг эсэх		
15	Ирсэн явсан бичгийн бүртгэл хөтөлдөг эсэх		
16	Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлсэн эсэх		
17	Улсын бүртгэлийн гэрчилгээнд шаардлагатай тэмдэглэл, өөрчлөлтийг хийлгүүлсэн эсэх		

IV. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Шалгах хуудас 5: Мөнгөн хөрөнгө

№	Асуумж	Шалгуур үзүүлэлт (тийм/үгүй/хангалтгүй)	Дүгнэлт/ зөвлөмж
1	Бэлэн мөнгөний үлдэгдэлд гэнэтийн болон ээлжит шалгалт тогтмол хийгдсэн эсэх		
2	Өдөр тутам касс дахь бэлэн мөнгийг тоолж, илүүдэл болон дутагдлыг бүртгэдэг эсэх		
3	Кассын дэвтэр хөтөлдөг эсэх, кассын дэвтрийн гүйлгээ орлого зарлагын баримт болон бусад тайлантай таарч байгаа эсэх		
4	Бэлэн мөнгөөр гүйлгээ хийсэн тухай бүр тооцооны хуудас үйлдэн гарын үсгээр баталгаажуулдаг эсэх		
5	20 сая төгрөгөөс дээш дүнтэй бэлэн мөнгөний төлбөр тооцооны гүйлгээний мэдээллийг СМА-нд мэдээлдэг эсэх		
6	Ажил гүйлгээ ерөнхий журнал болон дансны хуулгатай тохирч байгаа эсэхэд анхан шатны баримттай тулган баталгаажуулалт хийдэг эсэх		
7	Гүйцэтгэх захирал мөнгөн хөрөнгийн дансдын гүйлгээ, үлдэгдлийг сар бүрийн эцэст дансны хуулгатай тулган баталгаажуулдаг эсэх		
Банкан дахь мөнгөн хөрөнгийн гүйлгээ			
8	Бэлэн бус гүйлгээг ХЗХ-ны нэр дээрх арилжааны банкан дахь харилцах дансаар дамжуулж хийдэг эсэх		
9	Данс бүрийн үлдэгдлийн хуулгыг ерөнхий журнал болон банкуудын хуулгатай тулган нягтлахад таарч байгаа эсэх		
10	Бүх шилжүүлгийн гүйлгээ батлагдсан бодлого, журмын дагуу хийгддэг эсэх		
11	Зарлагын гүйлгээнүүд зөв зохистой бүртгэгдсэн, холбогдох байгууллагуудтай тооцоо нийлж, акт үйлдсэн эсэх		
12	Сонгуульт гишүүд, гүйцэтгэх захирлын хадгаламж, хувь хөрөнгө, зээлийн дансуудаас зарим гүйлгээг түүвэрлэн ерөнхий журналд бичигдсэн гүйлгээ,		

харьцсан дебит, кредит дансуудтай тулган шалгахад сэжигтэй зүйл ажиглагдаагүй эсэх	
--	--

Шалгах хуудас 6: Зээлийн үйл ажиллагаа

№	Асуумж	Шалгуур үзүүлэлт (тийм/үгүй/хангалтгүй)	Дүгнэлт/ зөвлөмж
1	Зээл олголтын гүйлгээ дансны хуулга, санхүүгийн анхан шатны баримттай тохирч байгаа эсэх		
2	Зээлжих чадамжаас хэтрүүлэхээс урьдчилан сэргийлэх судалгаа тооцоо хийдэг (өр, орлогын харьцаа гэх мэт) эсэх		
3	Зээлийн хүүгийн бодолтыг “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох, мэдээллийн ил тод байдлыг хангах аргачлал”-ын дагуу зөв бодсон эсэх		
4	Зээлийн гэрээг гишүүнтэй Иргэний хуульд заасны дагуу байгуулдаг эсэх		
5	Шаардагдах барьцаа, баталгаагаар хангагдсан эсэх		
6	Барьцаа хөрөнгийг балансын гадуур бүртгэсэн эсэх		
7	Барьцаа хөрөнгийн гэрчилгээ, холбогдох бичиг баримт балансын гадуурх бүртгэлтэй таарч байгаа эсэх		
8	Зээлийн дүгнэлт, зээлийн хорооны хурлын тэмдэглэл, шийдвэрүүдийг албан ёсоор баталгаажуулсан, баримт бүрэн эсэх		
9	Зээлийн шалгах баланс ерөнхий журналын холбогдох дансуудтай таарч байгаа эсэх		
10	Хугацаандаа төлөгдөөгүй зээлтэй ажиллах шат дараалсан арга хэмжээг хэрэгжүүлдэг эсэх		
11	Хугацаандаа төлөгдөөгүй зээлийн хүүгийн төлбөр, хугацаа хэтрэлтийн тайланг үнэн зөв гүйцэтгэдэг эсэх		
12	Балансын гадуур гаргасан зээлийн эргэн төлөлтийн тайланг тэргүүлэгчдийн зөвлөлд сар бүр тайлагнасан эсэх		
13	Зээлийн ангиллыг зөв хийсэн, эрсдэлийн санг журмын дагуу байгуулсан эсэх		
14	Зээлийн эрсдэлийн сангаас хаасан зээлийг төлүүлэх ажиллагааг үргэлжлүүлэн хийдэг эсэх		
15	Зээлийн эрсдэлийн сангийн зардлын буцаалт дансны гүйлгээ үнэн зөв тайлагнагдсан эсэх		
16	Зээлийн мэдээллийн сантай гэрээ байгуулсан эсэх		
17	Зээлийн мэдээллийн санд зээлийн мэдээллийг тогтмол нийлүүлдэг эсэх		

Шалгах хуудас 7: Авлага, өр төлбөр

№	Асуумж	Шалгуур үзүүлэлт (тийм/үгүй/хангалтгүй)	Дүгнэлт/ зөвлөмж
1	Урьдчилж төлсөн зардал болон бусад авлагын дэд журналууд ерөнхий журналтай таарч байгаа эсэх		

2	Урьдчилж төлсөн зардал болон бусад авлагатай холбоотой гэрээ, нэхэмжлэх зэрэг анхан шатны баримтууд бүрэн эсэх		
3	Өр төлбөрийн сар бүрийн төлөлтийн дүн, сарын эцсээрх цэвэр дүнг тооцоолж тулгадаг эсэх		
4	Өглөгийн дансанд 6 сараас дээш хугацаатай байгаа тооцоог хэрхэх талаар зохицуулалтыг холбогдох журамд тусгасан эсэх		
5	Гаднаас авсан зээлийн дүн, гэрээг нягтлахад зохих журмын дагуу байгаа эсэх		
6	Гаднаас авсан зээл мөнгө угаах гэмт хэрэгтэй хамааралгүйг нотлох нотолгоотой эсэх		
7	Бусдаас авсан зээлийн хүүгийн тооцоолол холбогдох дэд дансдын хуулгатай таарч байгаа эсэх		
8	Бүртгэлтэй бусад төрлийн өглөг, өр төлбөрүүд, хуримтлагддаг дэд дансуудтай тохирч байгаа, ерөнхий журналтай таарч байгаа эсэх		
9	Дэд дансдын үлдэгдэл холбогдох анхан шатны баримтуудтай таарч байгаа эсэх		
10	Бусад авлага, бусад өглөгийн дансны дэлгэрэнгүйг шалгахад бүртгэх ёсгүй зүйл бүртгэгдээгүй байгаа эсэх		

Шалгах хуудас 8: Үндсэн хөрөнгийн бүртгэл

№	Асуумж	Шалгуур үзүүлэлт (тийм/үгүй/хангалтгүй)	Дүгнэлт/ зөвлөмж
1	Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийг ерөнхий журналтай тулгахад таарч байгаа эсэх		
2	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал болон хуримтлагдсан элэгдлийн тооцооллыг зөв хийсэн эсэх		
3	Өмнөх хяналтаас хойш шинээр худалдан авсан хөрөнгүүдийн хувьд эрх бүхий этгээдийн шийдвэр гарсан, нэхэмжлэх, төлбөрийн баримт, гүйлгээ хуулгаар баталгаажсан эсэх		
4	Хямдруулж зарсан хөрөнгийн анхан шатны баримт бүрэн, холбогдох олз, гарзын тооцоололтой холбоотой залруулга хийгдсэн эсэх		
5	Дахин үнэлгээ хийсэн хөрөнгө, тэдгээртэй холбоотой шийдвэр, холбогдох гүйлгээний бүртгэлийг үнэн зөв хийсэн эсэх		
6	Өмчлөх бусад хөрөнгөтэй холбоотой бодлого, журам оновчтой эсэх		
7	Өмчлөх бусад хөрөнгийн дэд журнал ерөнхий журналтай таарч байгаа эсэх		
8	Өмчлөх бусад хөрөнгөтэй холбоотой эрх зүйн статус, барьцаалах, эзэмших, өмчлөхтэй холбоотой баримтууд бүрэн эсэх		
9	Өмчлөх бусад хөрөнгийн хувийн хэрэгт хөрөнгийн үнэлгээ байгаа эсэх		
10	Өмчлөх бусад хөрөнгөтэй холбоотой өмнөх жилийн зардлуудын дэлгэрэнгүй бүртгэл анхан шатны баримтуудтай таарч байгаа эсэх		
11	Борлуулалтын олз, гарзыг зохистой тооцсон эсэх		

12	Борлуулалтын шийдвэрийг тэргүүлэгчдийн зөвлөлөөр баталсан хурлын тэмдэглэл, шийдвэр байгаа эсэх	
----	---	--

Шалгах хуудас 9: Хадгаламжийн үйл ажиллагаа

№	Асуумж	Шалгуур үзүүлэлт (тийм/үгүй/хангалтгүй)	Дүгнэлт/ зөвлөмж
1	Хадгаламж эзэмшигч гишүүдийн бүртгэлээс (түүвэр/нэг бүрчлэн) сонгож шалгахад хувийн хэргүүдийн бүрдэл, баримтжуулалт холбогдох бодлого, журмыг хангаж байгаа эсэх		
2	Хадгаламжийн хүүний бодолтыг “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох, мэдээллийн ил тод байдлыг хангах аргачлал”-ын дагуу зөв бодсон эсэх		
3	Шинээр татан төвлөрүүлсэн хадгаламжийн гүйлгээг дансны хуулга, санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгахад бүртгэл бүрэн, үнэн зөв эсэх		
4	Нэрийн данс нэг бүрийн орлого, зарлагын гүйлгээ харилцахын гүлгээтэй таарч байгаа эсэх		
5	Нэрийн данс нэг бүрийн хүүгийн тооцоолол зөв хийгдсэн эсэх		
6	Гэрээг цуцалж олгосон хадгаламжийн гүйлгээ, нийт дүн, ногдох хүүгийн тооцоолол бүртгэл үнэн зөв эсэх		
7	Хадгаламжийн орлого зарлага, хүүгийн орлого зарлагын гүйлгээг гишүүдийн хувийн хэрэг дэх бүртгэлд гүйлгээ бүрээр хийсэн, гишүүд танилцаж гарын үсгээр баталгаажуулсан эсэх		

Шалгах хуудас 10: Хоршооны өөрийн хөрөнгө, гишүүдийн хувь хөрөнгө

№	Асуумж	Шалгуур үзүүлэлт (тийм/үгүй/хангалтгүй)	Дүгнэлт/ зөвлөмж
1	Гишүүдийн хувь хөрөнгийн дансууд ерөнхий журналтай таарч байгаа эсэх		
2	Тухайн жилийн хувь хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээ, тэдгээртэй холбоотой баримт, анхан шатны баримттай таарч байгаа эсэх		
3	Гишүүдийн хувь хөрөнгө байвал зохих дээд, доод хэмжээний хязгаарыг зөрчөөгүй эсэх		
4	Идэвхгүй гишүүний хувь хөрөнгөтэй холбоотой эрх бүхий этгээдийн шийдвэрээр хийгдсэн гүйлгээ ерөнхий журналтай таарч байгаа эсэх		
5	Хувь хөрөнгийн орлого зарлагын гүйлгээг гишүүдийн хувийн хэрэг дэх бүртгэлд гүйлгээ тус бүрээр хийж, гишүүд танилцаж гарын үсгээр баталгаажуулсан эсэх		
6	Нөөцийн сан болон бусад сангуудын дэд дансууд ерөнхий журналтай таарч байгаа эсэх		
7	Сангуудад хийх цэвэр орлогын хуваарилалтыг бүх гишүүдийн хурлын шийдвэрийн дагуу хийсэн эсэх		

8	Нийгмийн хөгжлийн сангийн зарцуулалт, холбогдох баримт нотолгоо журмын дагуу бүрэн эсэх		
9	Тайлант үеийн цэвэр орлого нь орлого үр дүнгийн тайланд зөв тусгагдсан эсэх		

Шалгах хуудас 11: Орлого, зардлын данс

№	Асуумж	Шалгуур үзүүлэлт (тийм/үгүй/хангалтгүй)	Дүгнэлт/ зөвлөмж
1	Зээлийн хүүгийн орлогын тооцооллын тайлан ерөнхий журналын холбогдох данстай таарч байгаа эсэх		
2	Орлогын бусад дансуудын тайлан, гүйлгээ ерөнхий журнал, харилцах дансны хуулгатай таарч байгаа эсэх		
3	Цалин, урамшууллын тайлангууд ерөнхий журналын холбогдох данстай таарч байгаа эсэх		
4	Зардлын дэд дансдын тайлан ерөнхий журналын холбогдох данстай таарч байгаа эсэх		
5	Бусад зардлын дансны гүйлгээ харилцах дансны хуулга, зарцуулалтын баримттай таарч байгаа эсэх		

Шалгах хуудас 12: Тусгайлсан хяналт

№	Асуумж	Шалгуур үзүүлэлт (тийм/үгүй/хангалтгүй)	Дүгнэлт/ зөвлөмж
1	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу гишүүний анкетад “Улс төрд нөлөө бүхий этгээд” мөн эсэх гэсэн асуулга оруулсан эсэх		
2	Дүрмийн өөрчлөлтийг СЗХ-нд хүргүүлж хянуулсан эсэх		
3	Дүрэмд заасан гишүүнчлэлийн нөхцөлийг зөрчиж гишүүн элсүүлээгүй эсэх		
Ногдох хувь хөрөнгийн хуваарилалт			
4	Ногдох хувь хөрөнгийн хуваарилалтыг бүх гишүүдийн хурлаар дүрмийн дагуу шийдвэрлэсэн эсэх		
5	Бүх ногдох хувь хөрөнгийг бүх гишүүдийн хурлын шийдвэрийн дагуу зохистой тарааж, гишүүдийн хувийн хэрэг дэх бүртгэлд тэмдэглэсэн эсэх		
6	Хуулийн 44.4-д заасны дагуу тэргүүлэгчдийн зөвлөл гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн бүртгэлийг хөтөлж, гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд ногдох хувь хөрөнгийг жилд нэгээс доошгүй удаа хувь тэнцүүлэн хуваарилж байгаа эсэх		
Сонгуульт гишүүд, гүйцэтгэх захирал, ажиллагсдын дансны хяналт			
7	Сонгуульт гишүүд, гүйцэтгэх захирал, ажиллагсдын хадгаламж, хувь хөрөнгө, зээлийн дансны жагсаалт бүрэн эсэх		

8	Жагсаалтыг нэг бүрчлэн эсвэл зарим дансдыг түүвэрлэн хийгдсэн гүйлгээнүүдийг харилцах болон кассын дансны хуулга, тэдгээрийг нотлох баримтуудтай тулгахад таарч байгаа эсэх		
Гишүүдийн дансны үлдэгдлийн баталгаажуулалт			
9	Гишүүдийн хадгаламж болон зээлийн дансны үлдэгдлийг баталгаажуулсан эсэх		
10	Баталгаажуулалтыг нэг бүрчлэн хийдэг эсэх		
11	Хяналтыг хийж эхлэхдээ гишүүдэд мэдэгдэл явуулдаг эсэх		
12	Баталгаажуулалтыг хийдэг тогтсон аргатай (утсаар, и-мэйлээр, нүүр тулж гэх мэт) эсэх		
13	Бүх баталгаажуулалтын хариуг бүрэн авч чаддаг эсэх		

Шалгах хуудас 13: Мэдээллийн аюулгүй байдал

№	Асуумж	Шалгуур үзүүлэлт (тийм/үгүй/хангалтгүй)	Дүгнэлт/ зөвлөмж
1	ХЗХ нь мэдээлэл, технологийн аюулгүй байдлыг хангах бодлого эсвэл журамтай эсэх		
2	Мэдээллүүдээ нөөц хувь болгон өөр газар хадгалдаг эсэх		
3	Компьютерийн системд зөвхөн эрх бүхий ажилтнууд нэвтрэх эрхтэй, эрхгүй хүн нэвтрэхээс хамгаалагдсан эсэх		
4	Системд асуудал үүсэх үед авах арга хэмжээний төлөвлөгөөтэй /бичгээр/ эсэх		
5	Нягтлан бодох бүртгэлийн програмыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн эсэх		

V. ХЗХ-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ХИЙСЭН ДОТООД ХЯНАЛТЫН НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ

ХЗХ-ны нэр:

Он/сар/өдөр: /..... /....

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ (Тийм)	ШАЛГАЛТЫН ҮНЭЛГЭЭ		ӨМНӨХ ШАЛГАЛТААР ӨГСӨН ҮНЭЛГЭЭ (Тийм)	ӨӨРЧЛӨЛТ
			Тийм	Үгүй/ Хангалтгүй		
ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ДҮРЭМ, ЖУРМУУД						
1	Бодлогын баримт бичиг, дүрэм, журмууд	11				
УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА						
2	Тэргүүлэгчдийн зөвлөлийн үйл ажиллагаа	23				
3	Зээлийн хорооны үйл ажиллагаа	9				
4	Гүйцэтгэх албаны үйл ажиллагаа	17				

САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА						
5	Мөнгөн хөрөнгө	12				
6	Зээлийн үйл ажиллагаа	17				
7	Авлага, өр төлбөр	10				
8	Үндсэн хөрөнгийн бүртгэл	12				
9	Хадгаламжийн үйл ажиллагаа	7				
10	Хоршооны өөрийн хөрөнгө, гишүүдийн хувь хөрөнгө	9				
11	Орлого, зардлын данс	5				
12	Тусгайлсан хяналт	13				
13	Мэдээллийн аюулгүй байдал	5				
НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ		150				

Хяналтын зөвлөлийн дүгнэлт: Хяналтын зөвлөлийн гишүүд бид хоршооны үйл ажиллагаанд хийх энэ удаагийн шалгалтын хугацааг 20... /.../... -20.../.../... -ний хоорондох хугацааг хамруулан хийсэн бөгөөд Шалгах хуудас ...-...-ын дагуу шалгалтыг хийж гүйцэтгэлээ. Шалгалтыг хяналтын зөвлөлийн ... гишүүн бүрэн бүрэлдэхүүнээр хийж гүйцэтгэсэн бөгөөд шалгалтын тайланг үндэслэн хоршооны үйл ажиллагааг Хэвийн/Хэвийн бус/доогуур зурах/ гэж дүгнэж байна. Энэхүү шалгалтын тайлан болон цаашид анхаарч ажиллах зөвлөмжийг бичгээр гарган тэргүүлэгчдийн зөвлөл болон гүйцэтгэх албанд хүргүүлсэн болно.

Хяналтын зөвлөлийн дарга: /...../

Хяналтын зөвлөлийн гишүүн: /...../

Хяналтын зөвлөлийн гишүүн: /...../